

ЦАХИМ ШУУДАНД

50 СУВИЛАГЧИД МӨНГӨН УРАМШУУЛАЛ ГАРДУУЛАВ



Сувилагч нарын баярын өдрийг тохиолдуулан Эрүүл мэндийн яам, "Эрүүл мэнд хөгжлийн тулгуур" ТББ, "Ард" санхүүгийн нэгдлийн хамт олон хамтран "Ковид-19" цар тахлын эсрэг тууштай тэмцэж буй Цэргийн төв эмнэлгийн 50 сувилагчид тус бүр нэг сая төгрөгийн мөнгөн урамшуулал гардууллаа.

Энэ үеэр Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлого хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Буянтогтох "Хос тангарагтан алба хаагчдаа энэхүү урамшууллыг гардуулан өгч байгаадаа туйлын их баяртай байна. "Ковид-19" цар тахал анх дэгдсэнээс хойш батлагдсан тохиолдлуудыг эмчилж буй хоёр эмнэлгийн нэг нь Цэргийн төв эмнэлэг юм. Харин өнөөдөр илүү хүндэрсэн өвчтөнүүдийг эмчилж эдгээж байна. Тиймээс маш том гавьяа байгуулж буй сувилагчдаа нийт ард түмнийхээ өмнөөс баярласан сэтгэлээ илэрхийлж байна" гэсэн бол "Ард" санхүүгийн нэгдлийн

үйл ажиллагаа хариуцсан захирал Ж.Алтангүний "Манай байгууллага нийгмийн хариуцлагынхаа хүрээнд энэ цагийн баатрууд болох нийт сувилагчдаа сэтгэлийн дэм өгч, багахан хэмжээний хандив өргөж байна. Энэ хүрээнд цар тахлын улаан бүсэд тасралтгүйгээр ажиллаж буй Цэргийн төв эмнэлгийн сувилагчдыг сонгон, тус үйл ажиллагааг зохион байгуулж байна" гээд Цэргийн төв эмнэлгийн нийт сувилагчдад цаашдынх нь ажил үйлсэд өндөр амжилтыг хүсэн ерөөв.

Олон улсын сувилагчдын нийгэмлэг 1974 оноос эхлэн Орчин үеийн сувилахуйн ухааныг үндэслэгч хэмээн алдаршсан Английн сувилагч Флоренс Найтенгелийн төрсөн өдөр буюу 5 дугаар сарын 12-ныг "Сувилагч нарын баярын өдөр" болгон тэмдэглэх байгаа бөгөөд дээрх урамшуулалд нийт 100 сувилагчийг хамруулсаны 50 нь Цэргийн төв эмнэлгийн сувилагчид юм.

ИЛТГЭЛИЙН УРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАВ

Зэвсэгт хүчний 150 дугаар анги

"Зэвсэгт хүчинд эмэгтэйчүүдийн оролцоо, тэдний дуу хоолой" сэдвээр жендерийн тухай сургалт, илтгэлийн

хүсэж, идэвхтэй оролцохыг уриалан Жендерийн эрх тэгш байдлын тухай мэдээлэл өгөв. Мөн захиргаачийн орлогч, захиргааны удирдлагын тасгийн дарга, дэд хурандаа П.Түмэнжаргал "Жендер гэж юу



уралдааныг ангийн байрлалд зохион байгуулж явууллаа. Жендерийн сургалт, илтгэлийн уралдаанд цэргийн алба хаагчдаас гадна ангийн энгийн ажилтан алба хаагчид хамрагдлаа. Ангийн захирагч хурандаа

вэ? Жендерийн тэгш байдлын тухай ойлголт", "Ажлын байран дах жендерийн эрх тэгш байдал хүний эрх" сэдвээр хичээл зааж сэдвийн хүрээнд харилцан яриа, хэлэлцүүлэг зохион байгуулсан юм. Илтгэлийн уралдаанд 22 хүн

ЭРҮҮЛ МЭНДИЙН МАНААНД БАТ ЗОГСОЖ БУЙ ТА НАРТАА БАЯРЛАЛАА

БХЯ-ны "Барилга захиалагчийн алба" ТӨААТҮГ нь нийгмийн хариуцлагынхаа хүрээнд халдварын голомтод ажиллаж буй Цэргийн төв эмнэлгийн Хүүхдийн тасгийн эмч, сувилагч, үйлчлэгч нарынхаа дархлааг дэмжих, халдвараас сэргийлэх зорилгоор 25 хүний багцыг "Олон Улсын сувилагчдын баяр"-ын өдөр буюу 5 дугаар сарын 12-ны өдөр хүлээлгэн өглөө.

"Өнгөрсөн хугацаанд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд тэргүүн шугамд тэмцэж явсан хүмүүсийн нөр их зүтгэлд чин сэтгэлээсээ талархаж байна. Дэлхий нийтийг хамарсан цар тахлын хүнд хэцүү цагт иргэдийн эрүүл мэндийг хамгаалах үйлсэд гар бие оролцож байгаад талархан ийнхүү дэмжлэг үзүүлж байна. Энд ажилтан, алба хаагчдын маань сэтгэлийн хандив нэгдсэн ба дархлаа дэмжих багц маань хүнд хэцүү цагт жаахан ч гэсэн нэмэр болно гэдэгт найдаж байна гэж "Барилга захиалагчийн алба" ТӨААТҮГ-ын захирал, дэслэгч Э.Мөнхнаран онцолсон юм.



Г.Ялалт арга хэмжээг нээж "Зэвсэгт хүчинд эмэгтэйчүүдийн дуу хоолой" гэсэн жендерийн асуудлаар байр сууриа илэрхийлсэн илтгэлийн уралдаанд оролцож байгаа эмэгтэйчүүдэд ажлын амжилт

оролцсоноос ахлагч С.Нямсүрэн, дэд ахлагч Б.Орхон А.Оюунгэрэл, З.Отгонжав, Ж.Анударь нар эхний байруудад шалгарлаа.

Ахмад Г.БИЛГҮҮН


ТҮҮХЭН ҮНЭНИЙГ ГУЙВУУЛАХ БОЛОМЖГҮЙ

Монгол, Оросын судлаачид, эрдэмтдийн хамтарсан "Дэлхийн хоёрдугаар дайн, түүний сургаж" сэдэвт Эрдэм шинжилгээний цахим хурал боллоо.

Эх орны дайны ялалтын 76 жилийн ойд зориулсан энэхүү хурлыг нээж БХЭШХ-гийн захирал, доктор, профессор, хурандаа Б.Мөнхсайхан хэлсэн үгэндээ "Эх орны дайны болон Алс дорнодод Дэлхийн хоёрдугаар дайны төгсгөлийн цэргийн ажиллагааны тухай түүхийг гуйвуулж буй завхруулагчидтай хийх тэмцэлд иймэрхүү арга хэмжээ зохион байгуулж, түүхийн үнэнийг хадгалах нь өнөө цагт нэн чухал байгаа"-г цохон тэмдэглэв.

ОХУ-ын Бүгд найрамдах Буриад улсын Засгийн газрын Шадар сайд В.Б.Цыбикжапов Дайны жилүүдэд Монголын ард түмнээс Улаан армид үзүүлсэн өгөөмөр тусламж, хагас сая агт морьд эд материалын төдийгүй, сэтгэл санааны гүн дэмжлэг болж, ялалтын баярт өдрийг ойртуулахад үнэтэй хувь нэмэр болсныг онцлоод Монгол ард түмэнд ялалтын баярын мэндчилгээ дэвшүүллээ.

Цахим хурлын үндсэн илтгэлийг БХЭШХ-гийн Цэргийн түүх судлалын төвийн дарга, доктор, хошууч Т.Сүхбаатар сонордуулав. Тэрээр "Монгол Ардын Хувьсгалт цэрэг Манжуурын стратегийн давших операцид" илтгэлдээ "Хэдийгээр анх дэвшүүлсэн зорилтоо



бүрэн хэрэгжүүлж чадаагүй ч Өвөр Монголыг Японы дарлалаас чөлөөлж чадсан юм. Энэ дайнд оролцсоноор Монгол Улсын тусгаар тогтнол баталгаажиж, олон улсын харилцаанд эрх зүйн нэгэн субъект болохоо харуулсан" гэв.

Дайны жилүүдэд Монголын ард түмэн "Бүхнийг фронтод, Бүгдийг ялалтын төлөө" уриан дор 700 шахам вагоноос бүрдсэн зургаан цуваа бэлэг илгээсэн тухай илтгэлийг доктор, дэд профессор Лха.Баяр бэлтгэжээ.

Манай ард түмэн 435 сая төгрөгийн мал, төрөл бүрийн эд зүйл, материал, 300 орчим кг алтыг ЗСБНХУ-д шилжүүлж, 485 мянган адууг хямд үнээр нийлүүлж, 32500 гаруй агт морьдоо фронтод бэлэглэжээ. Их Ялалт монголчууд бидний хувьд хүндэтгэлт баяр төдийгүй, мартагч учиргүй нандин түүх билээ.

Дайнд амь үрэгдсэн цэргүүдийг нэхэн тодруулах, дурсгалыг нь мөнхжүүлэх өргөн хүрээтэй ажил явагдаж буй талаар Бүх Оросын Цэрэг-эх оронч "Юнармия" хөдөлгөөний Буриадын салбарын штабын дарга дэд хурандаа В.В.Ефремов танилцуулсан. Мөн Монгол Улсын Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтсийн ерөнхий инженер, ахмад Э.Мөнх-Эрдэнэ "Монгол ард" нисэх эскадрилийн дайчин замналын сонирхолтой түүхийг хүргэсэн юм.

Цахим бага хурлын завсарлагаанаар "Дэлхийн хоёрдугаар дайн", "1945 оны Чөлөөлөх дайн"-ы сэдвээр бүтээсэн хоёр шинэ клипийг үзүүлсэн нь судлаачид, оролцогчдын сонирхлыг татлаа. Ийнхүү Эрдэм шинжилгээний энэ удаагийн хурал цэрэг-дайны түүхийн баримтыг судалгааны эргэлтэд оруулж, нийтийн хүртээл болгосон, эрдэмтэн судлаачид тухайн сэдвээр санал бодлоо солилцсон үр өгөөжтэй арга хэмжээ болов.

Бэлтгэл хурандаа Г.НЯМДОРЖ